


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар буюу **31 -р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 11 аймагт **1345** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1345 тохиолдлын 95% /1272/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /71/ нь орон нутагт (Баян-Өлгий /10/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Дорнод /4/, Орхон /4/, Өвөрхангай /6/, Өмнөговь /3/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /3/, Увс /1/), тодорхойгүй /2/ бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **374** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.


31 ДҮГЭЭР ДОЛОО ХОНОГТ

(2026.07.26 – 2026.08.01)

2026 оны гучиннэг дүгээр долоо хоногт 4 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 50 хувиар буурсан бол 5 жилийн дунджаас 11 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


**ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ**

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-31 дүгээр долоо хоногт нийт 1061** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны **гучин нэгдүгээр долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **35** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 52.20 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 101.2 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (31-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	15	10	25
2	Эмийн хордлого	6	4	10
Нийт		21	14	35

Нийт 35 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 10 (29%) нь эмийн хордлого, 25 (71%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 14 (40%) тохиолдол, санаатай хордлого 21 (60%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-оОо-